


Нутаг дэвсгэрийн хэмжээ, Газар зүйн байрлал, онцлогийн талаар

Хэнтий аймгийн Бор-Өндөр сум нь 1981 онд Хэрлэн хороо гэж байгуулагдаж, газар нутгийн харъяалал нь хуучнаар Хэнтий аймгийн Дархан сумын 5-р баг байсан. УИХ-ын 2012 оны 02 сарын 09 ний өдрийн 15-р тогтоолоор Бор-Өндөр сум болон өөрчлөгдөж, 2012 оны 12 дугаар сараас эхлэн сумын бүтэц зохион байгуулалтад орсон.

1-р баг /Бор-Өндөр/, 2-р баг /Холбоо/, 3-р баг /Бумбат/, 4-р баг /Уурхайчин/, 5-р баг /Хүйх/, 6-р баг /Өлгий/ гэсэн 6 багийн нийт 2660 өрх, 8883 хүн амтай.

Хүн амын тоогоор Хэнтий аймгийн 18 сумаас эхнээсээ 1-д, газар нутгийн хэмжээгээр 18-д ордог /аймгийн төвийг оролцуулалгүйгээр/ хүн амын нягтралаар хамгийн өндөр 60,99 хүн/га сум юм.

Газар зүйн байршил



Хэнтий аймгийн баруун өмнөд хэсэгт:

- Улаанбаатар хотоос 300 км,
- Хэнтий аймгийн төвөөс 180 км зайд байрладаг.
- Өмнөд хэсгээрээ Дорноговь аймгийн Айраг сум, бусад хэсгээрээ Хэнтий аймгийн Дархан сумтай хиллэдэг.

Байгаль, газарзүйн онцлог

Газарзүйн онцлог. Далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд Монголын дорнод талын их мужийн Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт,

Байгалийн бүсийн хувьд хуурай хээрийн бүсэд тус тус багтдаг. Газар хөдлөлийн эрчим 6 балл.

Цаг уурын нөхцөл.

Хуурайдуу сэрүүн зунтай, хахирдуу өвөлтэй.

- 1 дүгээр сарын дундаж температур -20 °C
- 7 дугаар сарын дундаж температур +25 °C
- жилийн дундаж салхины хурд 6-8 м/с
- жилийн хур тундасны нийлбэр 150-200 мм

Газар нутаг

Нийт газар нутгийн хэмжээ-**14400 га.**

Зориулалт	Хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Уул уурхайн зориулалттай газар	9500	67,8
Ойн сан бүхий газар	0	0
Усан сан бүхий газар	0	0
Тусгай хэрэгцээний газар	0	0
Тосгон, суурингийн газар	3000	21,5
Дэд бүтцийн газар	1500	10,7

Хүн амын тоо, яс үндэс

2017 оны байдлаар 8883 хүн тоологдсон ба үүнээс эрэгтэй 4442, эмэгтэй 4441. Нийт хүн амын 99.63 хувийг Халх ястан, 0.12 хувийг Казах ястан, 0.25 хувийг Дөрвөд ястан эзлэн амьдарч байна.



Хүн ам, өрхийн тоо

Үзүүлэлт	Хүн амын тоо
Хүн амын тоо	
Нийт эрэгтэй	4442
0-4 нас	534
5-9 нас	520
10-14 нас	334
15-19 нас	404
20-24 нас	393
25-29 нас	399
30-34 нас	391
35-39 нас	351
40-44 нас	290
45-49 нас	253
50-54 нас	236
55-59 нас	160
60-65 нас	80
65-аас дээш нас	97
Нийт эмэгтэй	4441
0-4 нас	508
5-9 нас	504
10-14 нас	399

15-18 нас	333
19-24 нас	323
24-29 нас	363
30-34 нас	335
35-39 нас	367
40-44 нас	354
45-49 нас	293
50-54 нас	237
55-59 нас	173
60-65 нас	109
65-аас дээш нас	143
Өрхийн тоо	2660
Суурин хүн ам	8883
Түр оршин суугч	880

Сумын бренд бүтээгдэхүүн

Бор-Өндөр сумын иргэн А.Мөнхбаатар нь сумын бренд бүтээгдэхүүн болох жоншоор том жижиг олон төрлийн бэлэг дурсгал хийхээс гадна мөнгөн аяга хөөрөг зэргийг хийдэг.

Жоншоор хийсэн сүлд




Хөөрөг болон аяга




Малын тоо ангилал, сүүлийн 5 жилээр графикаар

Сумын хэмжээнд 2017 оны байдлаар нийт 77,014 мянган мал тоологдсон.



Сумын малын тоог сүүлийн 5 жилээр графикаар харууллаа:



Сумын байгаль орчин, ан амьтан, хөрс ургамлын танилцуулга

Хөрсний шинж чанар: Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт тархсан хөрсийг шинж чанар газарзүйн байршил хөрс үүсгэгч нөхцөлөөр нь: 1. Долгирхог тал, хээрийн ба өргөн хөндийн хөрс 2. Голын хөндийн, нугын хээршсэн хөрс 3. Уулархаг, уулын хөрс 4. Хээрийн элсэрхэг, хүрэн хөрс гэж хуваана. Долгиорхог хээр талын ба өргөн хөндийн хөрс зонхилох хувийг эзлэнэ. Ховор тохиолдох нуур тойрмын зах хэсгээр хужир марзтай хөрс тохиолддог. Түр зуурын ус тогтдог хотгоруудад шаварлаг хөрс үүссэн байна. Хуурай сайрын хөндий болон тэгш талд элсэрхэг хөрс тархсан байна.

Ургамал зүйн байдал: Цахилдаг, алаг өвст, хиаг-хялганат, бужмаг, хонгорзул, улалж, бут бударгана, харгана, халгай, буурцагт өвсний төрөл зонхилно. Үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс болон амт чанар, шимт сайтай үетэн, буурцагт, алаг өвсний

төрлийн ургамал зонхилно. Мөн гол, булаг,нуур тойрмын хөвөөгөөр хиаг, хазаар өвс, салхин ерхөг, дэрс, харгана, адамсын агь, хэрс зэрэг ургамал ургадаг ба сумын урд говирхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботуульт ургамал зонхилон ургадаг байна. Нам доор хотгор газруудаар дэрс, хааяа тохиолдох булгийн дэргэд зэгс, сухай, бургас ургана.



Ан амьтан

Бор-Өндөр сум нь 77 мянган тоо толгой таван хошуу малтай, уул хадаараа 30 гаруй аргаль янгир бэлчдэг, цагаан зээр бэлчээрлэдэг, цаашдаа тарвага нутагшуулах зорилготой байна.



Уур амьсгал: Хуурай хээрийн, цөлөрхөг говь хээрийн уур амьсгал зонхилно. Дулаан зунтай чийг дутмаг мужид багтана. Бүх нутгаар агаарын хэмийн харьцангуй жигд тархалттай байдаг. Ургамшил тачирхан, чулуурхаг буюу элсэрхэг гадаргатай тул наранд халж агаарын хэмийг дээшлүүлдэг. Хамгийн их хүйтрэл 1-р сард, хамгийн их халуун 7-р сард болдог. Агаарын температурын сарын дундаж нь бүх нутгаар 8-13 градус байдаг ба олон жилийн дунджаар 1,5

градусаар дулаан байна. Жилд дунджаар 200 орчим мм тунадас унадаг. Нутгийн ноёлох салхи баруун хойноосоо ихэвчлэн салхилдаг ба хамгийн их салхи шуургатай үе 3, 4, 5-р сар юм.

Түүхийн дурсгалт газрууд

Бор-Өндөр сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт түүхийн дурсгалт газрууд оршдог. Эртний булш бунхан, хэргэсүүр байдаг. Олон овоот, зугаалгын хад, хүслийн мод, Далантүрүү рашаан, Агуйт зэрэг олон сайхан байгалийн үзэсгэлэнт газар байдаг.


Хүслийн мод



Хэргэсүүр



Зугаалгын хад



Агуй



Бөөрийн рашаан



Хэрмийн булаг



Далантүрүүний рашаан



Байгалийн баялаг, ашигт малтмалын орд газрын тухай

Уулын баяжуулах үйлдвэр нь 1981 онд ашиглалтанд орсон одоогийн байдлаар нийт 1135 ажилтан ажиллаж байна.

Хүчин чадал: Жоншны хүдэр олборлолт 300,000-360,000 тн

95%-н агуулгатай хайлуур жонш/csf2/ 140,000-160,000 тн

75%-н агуулгатай бүхэллэг жонш 15,000-20,000 тн

65%-н фторын агуулгатай төмрийн баяжмал 500,000 тн


Хуурай төмрийн баяжмал 205,000 тн

Нойтон төмрийн баяжмал 250,000 тн тус тус олборлож байна



Жижиг дунд үйлдвэрлэл

1. Бор-Өндөр суманд бүх төрлийн машинд деталь буюу хуучирч муудсан тоос татдаг элгэн хэсгийг арьсан материалаар сольж бүрэх үйлчилгээ хийгдэж байна. Мөн бүх төрлийн автомашины суудлын бүрээсийг захиалгаар хийж байна. /Улаанбаатарын ханшаар/



2. Бор-Өндөр сумын иргэн Р.Очирбат нь 2009 оноос “Бор-Өндөрт үйлдвэрлэв” дэлгүүрийг ажиллуулан өөрийн хийсэн сүү сүүн бүтээгдэхүүн, малын гаралтай түүхий эд болон үндэсний хувцас гоёл чимэглэлийн зүйлсийг хийн борлуулж байна.



Цаашид хөгжүүлэх боломжтой үйлдвэрлэл үйлчилгээ, сумын хэтийн хөгжлийн төлөвийн талаарх мэдээлэл

Бор-Өндөр орчмын сумдын нутаг дэвсгэрийн өнөөгийн судалгаанд тулгуурлан ашигт малтмалын ордыг ашиглан уул уурхайн үйлдвэрлэл, мал аж ахуйн түүхий эдэд түшиглэн малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, түүхэн дурсгалт газрууд, амралт рашаан сувилалд тулгуурласан дотоод гадаадын аялал жуулчлалыг хөгжүүлэн тойргийн сумдын эдийн засагт нөлөөлөхүйц бичил бүсийн төв болгон хөгжүүлэх хэтийн төлөв байна.

Энэ ажлын хүрээнд хийгдсэн хамгийн том алхам бол “Бор-Өндөр” хот байгуулалтын нэгдсэн төслийг Монгол орныг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалтай уялдуулан боловсруулж, Монгол Улсын Дэд Бүтцийн Хөгжлийн сайдын 1996 оны 10 дугаар 29-ний өдрийн 316 дугаар тушаалаар батлуулсан юм. Энэхүү төсөл нь Бор-Өндөр орчмын бичил бүсийг хөгжүүлэх төсөл, Бор-Өндөр хотын ерөнхий төлөвлөгөө, Бор-Өндөр хотын дэвсгэр нутгийн хот байгуулалт-эдийн засгийн үнэлгээ гэсэн үндсэн 3 хэсэгтэй бөгөөд дагалдах зураг төслийн хамтаар хийгдсэн байдаг.

